МОНГОЛ УЛС,БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН ХООРОНД ИРГЭНИЙ БОЛОН АЖ АХУЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

Г Э Р Э Э

Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэнэ/ нь:

Иргэний болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ач холбогдол өгөн;

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

I БҮЛЭГ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл
Эрх зүйн хамгаалалт

1.Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр хувийн болон эд хөрөнгийн талаар тухайн Талын иргэний нэгэн адил эрх зүйн хамгаалалт эдэлнэ.

2.Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдэд дээрх заалт мөн адил хамаарна.

3.Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний нэгэн адил нэхцөлөөр шүүхийн байгууллага буюу иргэний болон аж ахуйн хэргийн талаар асуудал эрхэлсэн бусад эрх бүхий байгууллагад чөлөөтэй хандах эрхтэй.

2 дугаар зүйл
Эрх, үүрэг болон нэхцөл

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийн нэгэн адил эрх, үүрэгтэйгээр тухайн улсын шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

3 дугаар зүйл
Харилцах журам

Хэлэлцэн тохирогч Талууд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхдээ Монгол Улсын хувьд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Бүгд

Найрамдах Энэтхэг Улсын хувьд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Хууль, эрх зүй, компаний асуудал эрхэлсэн яамаар дамжуулан харилцана.

II БҮЛЭГ

ИРГЭН, АЖ АХУЙН ХЭРГИЙН ТАЛААР ҮЗҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА БА ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА

4 дүгээр зүйл
Эрх зүйн туслалцааны хамрах хүрээ

Хэлэлцэн тохирогч Талууд Хүсэлт хүлээн авсан Талын холбогдох хуулийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж эрх зүйн дараахь туслалцааг харилцан үзүүлнэ. Тухайлбал баримт үйлдэх, илгээх, гардуулах, шилжүүлэх, зохигчид, гэрч, шинжээч болон бусад этгээдээс мэдүүлэг авах, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, арбитрын шийдвэрийг биелүүлэх, хүсэлтийг хангах зорилгоор эд хөрөнгийг хураах, түүнчлэн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай бусад арга хэмжээ зэрэг болно.

5 дугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг гаргах хэлбэр

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг бичгээр үйлдэх ба үүнд дараах зүйлийг тусгана:

1) хүсэлт гаргасан байгууллагын нэр;
2) хүсэлт хүлээн авсан байгууллагын нэр;
3) эрх зүйн туслалцаа үзүүлэх хэргийн нэр;
4) хүсэлтэд холбогдох этгээдийн овог нэр, иргэний харъяалал, байнга болон түр оршин суугаа газрын хаяг, ажил мэргэжлийн талаарх мэдээлэл, хуулийн этгээдийн хувьд түүний нэр, хаяг;
5) хүсэлттэй холбогдох этгээдийг төлөөлөх этгээдийн нэр, хаяг;
6)шаардлагатай бол тодруулах зарим зүйл буюу шаардлагатай баримт бичиг, бусад нотлох баримтыг хавсаргасан байна.

6 дугаар зүйл
Хүсэлт биелүүлэх журам

1.Хүсэлт хүлээн авсан Тал эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг биелүүлэхдээ өөрийн улсын хуулийг мөрдөнө. Хүсэлт гаргасан Талын хүсэлтээр Хүсэлт хүлээн авсан Тал өөрийн улсын хууль тогтоомжид харшлахгүй гэж үзвэл Хүсэлт гаргасан Талын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг хэрэглэж болно.

2.Хүсэлт хүлээн авсан Тал хүсэлтийг биелүүлэх эрх бүхий бус байвал түүнийг эрх бүхий байгууллагад шилжүүлэн өгч энэ тухайгаа Хүсэлт гаргасан Талд зохих ёсоор мэдэгдэнэ.

3.Хэрэв хүсэлтийг биелүүлэх боломжтой тохиолдолд Хүсэлт хүлээн авсан Тал Хүсэлт гаргасан Тал, сонирхогч талууд, түүний төлөөлөгчдөд хүсэлтийг биелүүлэх газар, хугацааг мэдээлнэ.

4.Хүсэлт хүлээн авсан Тал хүсэлтийг биелүүлсэн тохиолдолд баримт бичгийг Хүсэлт гаргасан Талд хүргүүлнэ. Хүсэлт хүлээн авсан Тал эрх зүйн туслалцаа үзүүлж чадаагүй бол хүсэлтийг буцаан хүргүүлж, биелүүлж чадаагүй тухай шалтгааныг мэдэгдэнэ.

7 дугаар зүйл
Баримт бичиг үйлдэх, шүүхийн
шийдвэрийг гардуулах

1. Хүсэлт хүлээн авсан Тал өөрийн хууль тогтоомжийн дагуу баримт бичиг үйлдэх буюу баримт бичгийг гардуулна. Хүсэлт хүлээн авсан Талын хэл дээр баримт бичгийг үйлдээгүй, орчуулгыг хавсаргаагүй тохиолдолд холбогдох этгээд шийдвэрийг хүлээн авахыг зөвшөөрвөл түүний хаягаар гардуулж болно.

2. Биелүүлэхийг хүссэн хүсэлтэд Хүсэлтийг хүлээн авах этгээдийн тодорхой хаяг, гардуулах баримт бичгийн нэрийг тусгасан байна.

8 дугаар зүйл
Баримт бичиг гардуулах буюу
үйлдснийг нотлох

Хүсэлт хүлээн авсан Талын нутаг дэвсгэр дээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм, журмын дагуу баримт бичгийг гардуулсан буюу үйлдсэн тухайгаа нотолно. Гардуулсан газар, цаг хугацаа түүнчлэн ямар хүнд гардуулснаа үйлчилгээний гэрчилгээнд зааж өгсөн байна.

9 дүгээр зүйл
Дипломат буюу консулын албаар дамжуулан
иргэдэд баримт бичиг гардуулах, мэдүүлэг авах

Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн Талын дипломат буюу консулын албаар дамжуулан өөрсдийн иргэдэд баримт бичиг гардуулах, мэдүүлэг авах эрхтэй. Дээрх ажиллагааг албадлагаар биелүүлж болохгүй.

10 дугаар зүйл
Гадаад улсын шүүхэд гэрч,
шинжээчээр дуудах

1.Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэр дээр шүүх ажиллагаа явуулах буюу урьдчилсан мөрдөн байцаалтад Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа гэрч буюу шинжээчийг биеэр байлцуулах шаардлага

гарвал гэрч буюу шинжээчийг шүүхэд дуудах хүсэлтийг Хэлэлцэн тохирогч негөө Талын холбогдох байгууллагад гаргана.

2.Шүүхийн зарлан дуудах бичигт дуудагдсан этгээдэд шүүхэд хүрэлцэн ирээгүй тохиолдолд ямар нэгэн шийтгэл оногдуулах тухай заалтыг тусгаж болохгүй.

3.Аль нэг улсын харъяат гэрч буюу шинжээч шүүхийн зарлан дуудахаар сайн дураар Хэлэлцэн тохирогч негөө Талын нутаг дэвсгэр дээр хүрэлцэн ирвэл түүнийг аливаа эрүүгийн буюу захиргааны хэрэгт яллаж болохгүй бөгөөд түүнийг уг Талын нутаг дэсгэрт орж ирэхээс өмнө үйлдсэн хэрэгт албадан саатуулах эсвэл шийтгэж болохгүй.

4.Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхийн зарлан дуудлагаар хүрэлцэн ирсэн Хэлэлцэн тохирогч негөө Талын гэрч буюу шинжээч Хүсэлт гаргасан Талаас түүнийг цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш 10 хоногийн дотор шүүхэд дуудсан Талын нутаг дэвсгэрээс гараагүй бол тэрээр энэхүү халдашгүй эрхээ алдана. Гэрч буюу түүнээс үл хамаарах шалтгаанаар тухайн улсын нутаг дэвсгэрээс гарч чадаагүй хугацааг дээрх хугацаанд тооцохгүй.

5.Хэлэлцэн тохирогч нэг Талын хүсэлтээр ирсэн гэрч буюу шинжээч замын зардал болон гадаадад байх хугацааны зардлыг хүсэлт гаргасан байгууллагаас нөхөн төлүүлэх эрхтэй. Шинжээч шалгалт, шинжилгээ хийсний хөлсийг авах эрхтэй.

6.Гэрч буюу шинжээчийг ирүүлэх хүсэлтэд ирүүлэхтэй холбогдох зардлыг төлөх тухай заасан байх бөгөөд энэхүү Хүсэлт гаргасан Тал холбогдох зардлын урьдчилсан төлбөрийг хийнэ.

7.Эрх бүхий комисс, байгууллагаас томилсон этгээдээр дамжуулан эсхүл Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн дагуу нотлох баримт гэж үзэж болох мэдүүлэг авах, асуулга буюу бусад хэлбэрээр гэрчийн мэдүүлэг авахад Хэлэлцэн тохирогч Талууд шаардлагатай бүхий л туслалцааг харилцан үзүүлнэ.

11 дүгээр зүйл
Баримт бичгийг хүлээн зөвшөөрөх

1.Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэр дээр зохих маягтын дагуу үйлдэж, эрх бүхий шүүхийн буюу албан тушаалтны (орон тооны орчуулагч, шинжээч г.м) албан ёсны тамга дарсан баримт бичгийг Хэлэлцэн тохирогч негөө Талын нутаг дэвсгэр дээр аливаа төрлийн баталгаажуулалт шаардахгүй.

2.Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэр дээр нууцын зэрэглэлгүйд тооцогддог баримт бичгийг Хэлэлцэн тохирогч негөө Талын нутаг дэвсгэрт нууцийн зэрэглэлгүйд тооцно.

12 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэх зардал

1.Хүсэлт хүлээн авсан Тал туслалцаа үзүүлсэнтэй холбогдон гарсан зардлыг негеө Талаас нэхэмжлэхгүй. Хэлэлцэн тохирогч Талууд өөрсдийн нутаг дэвсгэрт эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон гарсан аливаа зардлыг хариуцна.

2.Хүсэлт хүлээн авсан Тал Хүсэлт гаргасан Талд зарцуулсан зардлын хэмжээг мэдэгдэнэ. Хэрэв Хүсэлт гаргасан Тал тэдгээр зардлыг хариуцах ёстой этгээдээс нөхөн төлүүлэн авч чадвал уг зардлыг Хэлэлцэн тохирогч негеө Талын дансанд хийнэ.

13 дугаар зүйл

Иргэний гэрчилгээ, бусад
баримт бичгийг хүргүүлэх

Хэлэлцэн тохирогч Талууд хүсэлт гаргасны дагуу Хэлэлцэн тохирогч негеө Талын иргэдийн биеийн байцаалт болон иргэдийн хувийн болон өмчийн эрх ашигтай холбоотой бусад баримт бичгүүдийг (боловсролын, мэргэжлийн г.м) дипломат шугамаар орчуулгагүй болон үнэ төлбөргүйгээр харилцан хүргүүлэх үүрэгтэй.

14 дүгээр зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах

Хэрэв эрх зүйн туслалцаа үзүүлэх нь Хүсэлт хүлээн авсан Талын бүрэн эрхт байдал, аюулгүй байдалд хор уршиг учруулахуйц эсхүл хууль тогтоомжтой нь зөрчилдөж байвал Хүсэлт хүлээн авсан Тал эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

15 дугаар зүйл

Эрх зүйн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөх

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч негеө Талын нутаг дэвсгэр дээр Хэлэлцэн тохирогч негеө Талын иргэний адил хэмжээ, нөхцлөөр эрх зүйн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөнө.

16 дугаар зүйл

Хувийн, гэр бүлийн болон өмчийн
холбогдолтой баримт бичиг олгох

1.Эрх зүйн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөх зөвшөөрөл авахад шаардагдах хувийн, гэр бүлийн болон өмчийн холбогдолтой баримт бичгийг нутаг дэвсгэр дээр нь байнга буюу түр хугацаагаар оршин суух байгаа Хэлэлцэн тохирогч Талын зохих байгууллагаас гаргаж өгнө.

2.Хэрэв дээрх баримт бичгийг гаргуулан авч байгаа этгээд Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэр дээр байнга буюу түр хугацаагаар оршин

суугаагүй бол уг этгээдийн харъяалагдах улсын дипломат буюу консулын албанаас олгосон баримт бичгийг хангалттай гэж үзнэ.

3.Эрх зүйн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөх тухай шийдвэр гаргаж байгаа шүүх шаардлагатай бол холбогдох байгууллагаас нэмэлт мэдээлэл хүсч болно.

17 дугаар зүйл
Шүүх

1. Энэхүү Гэрээ болон Хэлэлцэн тохирогч Талуудын хуулинд өөрөөр заагаагүй бол хэрэв хариуцагч тэдгээрийн нутаг дэвсгэр дээр оршин суух байгаа тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талуудын шүүх иргэний болон аж ахуйн хэргээр хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрхтэй. Хуулийн этгээдийн хувьд Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэр дээр ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг эсхүл өөрийн салбартай байвал уг Талын шүүх дээрх эрхийг мөн эдэлнэ.

2.Арбитрийн шүүхийн үйл ажиллагаанаас бусад тохиолдолд дээрх шүүхийн харъяалах эрхийг зохигчдын хооронд тохиролцоогоор өөрчилж болохгүй.

3.Энэхүү Гэрээний дагуу Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий шүүхүүд ижил талуудын хооронд, нэг үндэслэлээр, нэг хэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж эхэлсэн бол сүүлд нь эхэлсэн шүүх хянан шийдвэрлэх ажиллагаагаа зогсооно.

18 дугаар зүйл
Иргэний эрхийн чадамж болон чадвар

1. Иргэний эрх зүйн чадамжийг тухайн иргэнийг харъяалах Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу тодорхойлно.

2.Хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг нутаг дэвсгэр дээр нь хуулийн этгээдийн эрх авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу тодорхойлно.

19 дүгээр зүйл
Иргэнийг сураггүй алга болсон, нас
барсанд тооцох буюу нас барсныг тогтоох

1.Иргэнийг сураггүй алга болсон, нас барсанд тооцох болон нас барсныг тогтоох асуудлыг хамгийн сүүлийн мэдээгээр уг иргэн амьд ахуй цагтаа харъяат байсан Хэлэлцэн тохирогч Талын зохих байгууллага хариуцна.

2.Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын хууль тогтоомжийн дагуу эрх ашиг нь хамгаалагддаг бол нутаг дэвсгэр дээр нь оршин суух байгаа этгээдийн хүсэлтээр энэхүү Талын холбогдох байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг сураггүй алга болсон, нас барсанд тооцох болон нас барсныг тогтоож болно.

3.Энэхүү зүйлийн 1, 2 дугаар хэсэгт заасан хэргүүдэд Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн улсын хуулийг хэрэглэнэ.

Өмчийн эрх зүйн харилцаа

20 дугаар зүйл
Өмчлөл

1.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг тэрхүү үл хөдлөх эд хөрөнгө оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2.Холбогдох байгууллагад бүртгүүлэхийг шаарддаг тээврийн хэрэгслийг өмчлөх эрхийг зохих бүртгэх байгууллага нутаг дэвсгэр дээр нь оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

3.Өмчлөх эрхийг олж авах, цуцлах болон өмчийн бусад эрхийг эдгээр эрх үүсэхэд үндэслэл нь болж өгсөн үйлдэл, нөхцөл байдал бий болсон үед тухайн өмч нутаг дэвсгэр дээр нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно. Талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол өмчлөх эрхийг олж авах, цуцлах болон өмчийн бусад эрхийг хэлцэл хийсэн газрын хуулиар тодорхойлно.

21 дүгээр зүйл
Хэлцлийн хэлбэр

1.Хөдлөх эд хөрөнгийн хувьд хэлцэл хийсэн Хэлэлцэн тохирогч Талын хуулийг хэрэглэнэ.

2.Үл хөдлөх эд хөрөнгийн хувьд тухайн үл хөдлөх эд хөрөнгө оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын хуулийг хэрэглэнэ.

22 дугаар зүйл
Хохирол

1.Холбогдох гэрээ, хэлцэл болон бусад хууль ёсны дагуу хийсэн үйлдлээс үүссэн хохирлоос бусад хохирлыг нөхөн төлөх үүргийг нутаг дэвсгэр дээр нь тухайн хохирол гарахад хүргэсэн үйлдэл, нөхцөл байдал бий болсон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2.Хэрэв хохирол учруулсан болон хохирогч этгээд Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн бол нэхэмжлэлийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хуулийг баримтална.

3.Энэхүү зүйлийн 1, 2 дугаар хэсэгт заасан хэргийг хохирол үүсэхэд хүргэсэн үйлдэл буюу нөхцөл байдал нутаг дэвсгэр дээр нь бий болсон Хэлэлцэн тохирогч Талын харъяалах шүүхээр хянан, шийдвэрлэнэ. Гэхдээ хохирогч хариуцагчийн оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

23 дугаар зүйл

Иргэдийн төлөөлөгчөөр консулын ажилтан оролцох нь

Хэрэв өөрөө эзгүй болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас зохих хугацаанд өөрийн эрх ашгийг хамгаалах боломжгүй байсан буюу өөрийн төлөөлөгчөө томилж амжаагүй тохиолдолд зөвшөөрлийн дагуу өв залгамжлалын асуудлаар уг иргэнийг Хэлэлцэн тохирогч Талын дипломат буюу консулын алба нь Хэлэлцэн тохирогч негөө Талын өмнө төлөөлж болно.

24 дүгээр зүйл

Хувь хүнд холбогдох зүйлийг шилжүүлэх

Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн байнга оршин суудагүй Хэлэлцэн тохирогч негөө Талын нутаг дэвсгэр дээр аялж явахдаа нас барсан тохиолдолд түүнтэй холбогдох эд зүйлийг тэр даруй түүнийг харъяалах Хэлэлцэн тохирогч Талын дипломат буюу консулын албанд шилжүүлнэ.

III БҮЛЭГ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ГҮЙЦЭТГЭХ

25 дугаар зүйл

Иргэний болон аж ахуйн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр болон эрүүгийн хэргийн хохирол төлүүлэх тухай шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх

Хэлэлцэн тохирогч Талууд иргэн, аж ахуйн хэргээр болон эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлыг төлүүлэхээр шүүхээс гаргасан хүчин төгөлдөр шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрч, гүйцэтгэнэ.

Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэр дээр биелүүлэх шаардлагагүй иргэний хэрэгтэй холбоотой асран хамгаалах, харгалзан дэмжих, итгэмжлэх, бүртгэлийн болон бусад байгууллагын шүүхийн шийдвэрийг шүүх тусгай хэлбэрээр шийдвэрлэх ажиллагаагүйгээр нэгэн адил хүлээн зөвшөөрнө.

26 дугаар зүйл

Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх олгох тухай хүсэлтийг авч хэлэлцэх

1.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх эрх олгох тухай хүсэлтийг тухайн шүүхийн шийдвэрийг биелүүлэх Хэлэлцэн тохирогч Талын шүүхийн харъяалалын дагуу шийднэ.

2.Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх олгох тухай хүсэлтийг эрх бүхий шүүхэд гаргана. Уг хүсэлтийг гаргахад тавигдах шаардлагыг тухайн шүүхийн шийдвэрийг биелүүлэх Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид заасан байна.

3.Хүсэлтэд түүнийг хүлээн авч байгаа Хэлэлцэн тохирогч Талын хэлнээ орчуулсан орчуулгыг хавсаргана.

27 дугаар зүйл
Шийдвэрийг биелүүлэх эрхийн тухай
баримт бичиг

Шүүхийн шийдвэрийг биелүүлэх эрх олгох тухай хүсэлтэд дараах баримт бичгийг заавал хавсаргана:

1.Шүүхээс гаргасан шийдвэр/тогтоолын баталгаат хувийг, хэрэв уг шийдвэрийн агуулгаас тодорхойгүй бол тухайн шийдвэр/тогтоол гүйцэтгэхийг нотолсон албан бичгийн хамт;

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгийн баталгаат орчуулга.

28 дугаар зүйл
Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаа

Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг тухайн шүүхийн шийдвэрийг биелүүлэх Талын хуулиар зохицуулна.

29 дүгээр зүйл
Зардал

Шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбогдон гарах зардлыг тухайн шийдвэрийг биелүүлэх Талын хуулиар зохицуулна.

30 дугаар зүйл
Шүүхийн шийдвэрийн хамрах хүрээ

Энэхүү Гэрээний 25-29 дүгээр зүйлүүдийн шүүхийн шийдвэртэй холбоотой заалт нь шүүх болон арбитрын шийдвэрээр баталсан эвлэрүүлэх гэрээ буюу зөвшилцөх тогтоолд мөн адил хамаарна.

31 дүгээр зүйл
Эд зүйл болон мөнгө шилжүүлэх

Энэхүү Гэрээний шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбогдсон заалт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр авсан эд зүйл болон мөнгийг шилжүүлэхтэй

холбогдсон харилцааг зохицуулсан Хэлэлцэн тохирогч Талуудын хуультай зөрчилдөхгүй байна.

32 дугаар зүйл
Харилцах хэл

Энэхүү Гэрээг хэрэгжүүлэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд өөрсдийн хэлийг хэрэглэх бөгөөд аливаа холбогдох баримт бичигт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын үндэсний хэл дээрх орчуулга эсхүл англи хэл дээрх хувийг хавсаргасан байна.

IV БҮЛЭГ

БУСАД ЗААЛТ

33 дугаар зүйл
Гэрээг батлах, дуусгавар болгох

1.Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичгийг солилцсон өдрөөс хойш 30 дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Гэрээг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа бичгээр мэдэгдээгүй бол энэхүү Гэрээ хүчинтэй хэвээр тооцогдоно. Ийнхүү цуцлах тухай мэдэгдэл өгсөн өдрөөс хойш зургаан сарын дараа энэхүү Гэрээ нь хүчингүй болно.

3. Энэхүү Гэрээг 2001 оны 1 сарын 3-ны өдөр монгол, хинди, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

4.Энэхүү Гэрээг тайлбарлахад маргаан гарвал англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ